



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 13 өдөр

Дугаар A/318

Арвайхээр

Орон тоо нэмж батлах тухай

Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан “Орон тооны жишиг норматив батлах тухай” 2018 оны А/024/11 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрд сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны туслах тогоочийн орон тоог нэгээр нэмэгдүүлж, нийт орон тоог 43-аар баталсугай.
2. Батлагдсан орон тоог 2019 оны 5 дугаар сарын 13-наас мөрдөж ажиллахыг төсвийн шууд захирагчид үүрэг болгосугай.
3. Батлагдсан орон тооны дагуу санхүүжилт олгож, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаярт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100691